



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/230-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага.....	16
4.3 Зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.АЛТАНХУЯГ ТАНАА

2022.03.25 № 172
танай _____ -ны № _____ -г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын ТЭЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Жаргалант сумын ТЭЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,582,032.5	1,453,997.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	902,010.2	705,713.9
33	АВЛАГА	390,655.1	346,954.6
35	БАРАА МАТЕРИАЛ	289,367.2	368,289.6
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	33,039.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,529,769.6	5,779,810.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,529,769.6	5,779,810.7
39200	Биет хөрөнгө	5,450,192.3	5,701,383.4
39300	Биет бус хөрөнгө	79,577.3	78,427.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,111,802.1	7,233,807.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	54,457.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	54,457.0
41300	Өглөг	0.0	54,457.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,111,802.1	7,179,350.9
51	Засгийн газрын хувь оролцоо	7,111,802.1	7,179,350.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,735,800.8	1,735,800.8
51200	Хуримтлагдсан үр дүн	3,567,708.8	3,635,257.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,808,292.5	1,808,292.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,111,802.1	7,233,807.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,078,173.6	3,874,696.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	850,100.8	173,171.8
110	Орлогын албан татвар	91,890.5	82,260.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	91,889.5	82,260.2
113	Хөрөнгийн албан татвар	4,350.0	36,345.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	753,860.2	54,566.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,041,403.9	891,470.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,041,403.9	891,470.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,186,669.0	2,810,053.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,673,917.1	3,602,669.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,673,917.1	3,602,669.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,177,966.2	3,487,280.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,967,273.1	2,095,211.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,504.0	274,795.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,378.4	59,310.0
2104	Хангамж, бараа материалын зардал	106,243.2	110,985.9
2105	Нормативт зардал	120,763.3	482,430.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,692.8	15,247.4
2107	Томилолт, зочны зардал	6,933.5	3,537.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,581.3	22,465.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	307,596.6	423,297.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	495,950.9	115,388.3

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,404,256.6	272,027.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	209,582.8	204,478.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,194,673.8	67,548.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,917,128.3	4,917,128.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,917,128.3	4,917,128.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	2,194,673.8	2,194,673.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,111,802.1	7,111,802.1
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,111,802.1	7,111,802.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,111,802.1	7,111,802.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	67,548.8	67,548.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,179,350.9	7,179,350.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,150,379.4	3,167,607.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	850,100.8	173,171.8
110	Орлогын албан татвар	91,890.5	82,260.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	91,889.5	82,260.2
113	Хөрөнгийн албан татвар	4,350.0	36,345.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	753,860.2	54,566.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,994.7	12,073.8
1181	Газрын төлбөр	5.4	19.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	741,860.1	42,472.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,609.7	274,440.7
120	Нийтлэг татварын бус орлого	113,609.7	274,440.7

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,186,669.0	2,719,994.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,133,559.2	2,966,790.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,133,559.2	2,966,790.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,634,173.5	2,856,378.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,963,603.6	2,050,006.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,194.0	267,050.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,583.9	61,319.8
2104	Хангамж, бараа материалын зардал	88,274.3	87,233.9
2105	Нормативт зардал	94,632.6	180,184.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,624.0	21,505.9
2107	Томилолт, зочны зардал	6,939.6	3,537.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,925.0	27,574.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,396.3	157,965.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	499,385.7	110,412.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,016,820.2	200,816.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	213,912.9	273,112.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,912.9	273,112.5
2200	Дотоод эх үүсвэрээр	213,912.9	273,112.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-213,912.9	-273,112.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-171,000.0	-124,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	171,000.0	124,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	631,907.3	-196,296.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	270,102.8	902,010.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	902,010.2	705,713.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт,	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,669,814.3	3,082,352.4	587,461.9	84.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,967,050.6	2,712,318.0	254,732.6	91.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,907,782.0	2,653,530.0	254,252.0	91.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,985,713.2	1,980,927.4	4,785.8	99.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,418.9	264,990.5	428.4	99.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,658.8	57,650.3	8.5	100.0
Хангамж, бараа материалын зардал	86,769.6	66,022.6	20,747.0	76.1
Нормативт зардал	125,799.9	98,751.2	27,048.7	78.5
Эд хогшил, урсгал засварын зардал	23,466.0	20,447.0	3,019.0	87.1
Томилолт, зочны зардал	4,436.5	3,335.5	1,101.0	75.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,317.1	29,502.8	814.3	97.3
Бараа үйлчилгээний бусад зардал	328,202.0	131,902.7	196,299.3	40.2

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,268.6	58,788.0	480.6	99.2
Бусад урсгал шилжүүлэг	59,268.6	58,788.0	480.6	99.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	524,363.7	246,034.4	278,329.3	46.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	178,400.0	124,000.0	54,400.0	69.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,676,728.9	3,323,250.9	353,478.0	90.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,051,554.9	2,039,975.4	11,579.5	99.4
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	508,425.5	993,511.7	(485,086.2)	195.4
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,537.2	23,838.1	22,699.1	51.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,070,211.3	265,925.7	804,285.6	24.8
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		106,322.2	(106,322.2)	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		345,774.4	(345,774.4)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	170.5	170.5	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Үзүүлэлт,	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	264,212.4
УРСГАЛ ЗАРДАЛ	255,562.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,276.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,078.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,060.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,669.5
Хангамж, бараа материалын зардал	21,277.7
Нормативт зардал	81,433.0
Эд хогшил, урсгал засварын зардал	4,998.4
Томилолт зочны зардал	201.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,994.0
Бараа үйлчилгээний бусад зардал	33,563.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,286.0
Бусад урсгал шилжүүлэг	34,286.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,650.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	264,212.4
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,212.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын ТЭЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд дотоод хяналт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 74 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сум нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд зааснаар хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байна.

Тус сум нь тайлант онд “Төрийн албыг хэвийн жигд, тасралтгүй ажиллах нөхцлийг хангах зарчмаар улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчилж, иргэдийн аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Сумын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус сумын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 3,676.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 36.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 25.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122.0 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	902.0	705.7	(196.3)	(21.8)
Авлага	390.6	346.9	(43.7)	(11.2)
Бараа материал	289.4	401.4	112.0	38.7
Үндсэн хөрөнгө	5,529.8	5,779.8	250.0	4.5
Нийт хөрөнгө	7,111.8	7,233.8	122.0	1.7
Өр төлбөр	-	54.5	54.5	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,111.8	7,179.3	67.5	0.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,111.8	7,233.8	122.0	1.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 21.8 хувиар буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн 705.7 сая төгрөгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 51.0 хувийг орон нутгийн ерөнхий орлогын дансны, 21.1 хувийг ОНХСангийн, 21.6 хувийг сум хөгжүүлэх сангийн, 0.3 хувийг ЭМТ-ийн үлдэгдэл, тус тус эзэлж байна.

- Авлагын үлдэгдэл өмнөх оноос 11.2 хувиар буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь тайлант онд СХС-ийн зээлийн эргэн төлөлт бусад сумдтай харьцуулахад харьцангуй сайн төлөгдсөнтэй холбоотой байна. Харин ЭМТ нь ковид цар тахалтай холбоотойгоор ЭМДС-аас 91.7 сая төгрөгийн авлагыг тайлагнажээ.

Нийт авлагын үлдэгдлийн 73.8 хувийг сум хөгжүүлэх сангийн, 26.2 хувийг ЭМТ-ийн авлага эзэлж байна.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 38.7 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 289.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 414.6 сая, хандиваар 374.4 сая, бусад 8.1 сая нийт 797.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 675.2 сая, бусад 9.9 сая нийт 685.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 401.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 29.0 хувийг ЭМТ, 25.3 хувийг ЕБС, 26.3 хувийг ЗДТГ, 11.3 хувийг хүүхдийн цэцэрлэг, 5.5 хувийг бага сургууль, 2.5 хувийг сумын соёлын төвийн, 0.1 хувийг ИТХ-ын бараа материалын үлдэгдэл тус тус эзэлж байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 5,529.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 91.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 37.8 сая, бусад 455.0 сая нийт 584.0 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө акталсны гарз 22.6 сая тайлант хугацаанд байгуулсан 311.4 сая төгрөгийн элэгдэл нийт 334.0 сая төгрөгөөр буурч, 5,779.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 50.7 хувийг ЕБС, 31.8 хувийг ЗДТГ, 6.4 хувийг ЭМТ, 5.7 хувийг хүүхдийн цэцэрлэг, 4.5 хувийг бага сургууль, 0.8 хувийг соёлын төвийн, 0.1 хувийг сумын ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

- Өр төлбөр 54.5 сая төгрөгөөр тайлагнагдсан нь сумын ЭМТ-ийн ажиллагсадтай холбоотой өглөг байна.
- Цэвэр хөрөнгө өмч нь өмнөх оноос 12.6 хувиар өссөн байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант үеийн үр дүнг 67.5 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Татварын орлого	850.1	173.2	(676.9)
Татварын бус орлого	2,041.4	891.5	(1,149.9)
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2,093.6	2,051.6	(42.0)
Орон нутгийн төсвөөс	1,033.4	380.4	(653.0)
Нэмэлт санхүүжилтийн орлого	24.4	354.3	329.9
НДСангаас санхүүжих	35.3	23.8	(11.5)
Үйл ажиллагааны орлогын дүн	6,078.2	3,874.8	(2,203.4)
Цалин, шимтгэлийн зардал	2,232.8	2,370.0	137.2
Бусад бараа үйлчилгээний зардал	321.0	671.6	350.6

Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	316.6	22.5	(294.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	307.6	423.3	115.7
Урсгал шилжүүлэг	495.9	115.4	(380.5)
Хөрөнгийн зардал	-	-	-
Үйл ажиллагааны зардал	3,673.9	3,602.8	(71.1)
Үйл ажиллагааны бус зардал	209.6	204.5	(5.1)
Үйл ажиллагааны үр дүн	2,194.7	67.5	(2,127.2)

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 42.0 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар буурчээ. Татварын бус орлого өмнөх оноос буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буюу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлууд өмнөх оноос буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт

Орон нутгийн төсвийн орлогыг 114.2 сая төгрөгөөр анх төсвийн төслийг боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна. Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны 2/07 дугаар “Төсөв батлах тухай” тогтоолоор төсвийн орлогыг 128.0 сая төгрөгөөр баталжээ.

Харин 2021 оны 9 дүгээр сарын 08-ны 5 дугаар тогтоолоор нийт орлогыг 0.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 128.8 сая төгрөгөөр тодотгон баталсан бөгөөд энэ нь бусад нэр заагдаагүй орлогыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/07 дугаар төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 3,570.8 сая төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 3,683.3 сая төгрөг болж, 112.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь ОНХС, ЗДТГ, ЕБС-ын зардлыг нэмэгдүүлж, хүүхдийн цэцэрлэгийн зардлыг бууруулсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Сумын төсвийн төлөвлөлт

сая төгрөгөөр

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	127.2	128.0	0.8
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	180.8	180.8	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	84.1	36.0	(48.1)
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	262.5	268.4	5.9
5	СӨБ-ийн үйлчилгээ	380.3	338.3	(42.0)
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,227.2	1,253.5	26.3
7	Соёлын үйлчилгээ	75.9	75.9	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	522.4	512.9	(9.6)
9	2020 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	701.6	795.7	94.1
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	8.7	93.7	85.0
	Нийт дүн	3,570.8	3,683.3	112.5

1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	77.7	77.7	-
2	Засаг даргын тамгын газар	836.0	845.7	9.6
3	Орон нутгийн хөгжлийн сан	271.2	362.2	90.9
4	Сум хөгжүүлэх сан	180.0	180.0	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	380.3	348.0	(32.3)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,227.2	1,271.4	44.3
7	Соёлын төв	75.9	75.9	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	522.4	522.4	-
	Нийт дүн	3,570.8	3,683.3	112.5

3.6.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 9 дугаар сарын 08-ны өдрийн 5 дугаар тогтоолд сумын төсвийн орлогоор 15 нэр төрлийн 128.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 182.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 141.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын төсвийн орлого

сая төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	128.8	182.5	53.6	141.6
2.УРСГАЛ ОРЛОГО	128.8	182.5	53.6	141.6
3.ТАТВАРЫН ОРЛОГО	65.0	173.2	108.1	266.3
4.Орлогын албан татвар	65.0	82.3	17.2	126.5
Хүн амын орлогын албан татвар	65.0	82.3	17.2	126.5
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	0.0	0.0	0.0	
Үйл ажиллагааны орлого	3.9	22.4	18.5	572.1
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	44.0	55.1	11.1	125.3
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	0.1	4.7	4.6	4,690.1
Шууд бус орлого	17.0	0.0		0.0
Өмчийн татвар	4.5	36.3	31.9	813.1
Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.0	0.0		
Малын тоо толгойн албан татвар	0.0	32.3		
Бууны албан татвар	4.5	4.0	-0.5	89.9
Бусад татвар	56.9	54.6	-2.4	95.8
Улсын тэмдэгтийн хураамж	3.8	2.7	-1.1	70.5
Газрын төлбөр	0.1	0.0	-0.1	
-----газрын төлбөр	0.1	0.0	-0.1	
-----Газрын дуудлага худалдааны орлого	0.0	0.0	0.0	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.0	1.0	0.0	103.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8.5	8.4	-0.1	98.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	43.6	42.5	-1.1	97.5
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	0.2	0.1	-0.2	32.7
----- ус рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0	
-----ойн нөөц ашигласны төлбөр	43.2	42.3	-1.0	97.8
-----ан амьтаны нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0	113.8
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2.4	9.3	6.9	388.0
Төсөвт газрын өөрийн орлого	0.8	0.8	0.0	99.6
Хүү торгуулийн орлого	0.8	8.3	7.5	1,039.4
Нэр заагдаагүй бусад орлого	0.8	0.2	-0.6	25.0

Тайлант жилд 8 нэр төрлийн орлого 179.0 сая төгрөгөөр давж биелсэн бол бууны албан татвар 0.4 сая, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.2 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.1 сая, хог хаягдлын хураамж 0.1 сая, нэр заагдаагүй бусад орлого 0.6 сая, ойн нөөц ашигласны төлбөр 1.0 сая, газрын төлбөр 0.05 сая төгрөгөөр тус тус тасарчээ. Энэ нь ковид цар тахалтай холбоотой хөл хорио тогтоосон, суманд бүртгэлтэй байсан галт зэвсгийн эзэмшигч өөрчлөгдсөн, иргэний бүртгэлийн орлого нь аймгийн төсөвт төвлөрдөг болсон зэрэгтэй холбоотой байна.

Харин шууд бус орлого 17.0 сая төгрөгөөр тасарсан нь ХХОАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2-т заасны дагуу үйл ажиллагааны орлогод малчин иргэдийн малын гаралтай түүхий эд борлуулсан орлогыг хамааруулж, ноос ноолуурын урамшууллаас авах татварыг үйл ажиллагааны орлого руу тайлагнах болсноос шалтгаалжээ.

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,683.3 сая төгрөгийн төсөв баталсныг төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,676.7 сая төгрөг буюу 6.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь тайлант оны эцэст ЕБС-ийн зардлыг 8.1 сая төгрөгөөр, хүүхдийн цэцэрлэгийн зардлыг 7.3 сая төгрөгөөр бууруулж, харин бага сургуулийн зардлыг 8.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвт зохицуулалт хийснийг сумын ИТХ-аар тодотгон батлаагүйтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зардлыг 3,676.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 2,973.9 сая төгрөгийг урсгал зардалд, 524.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 178.4 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар төлөвлөж, нийт зардлын 2,051.6 сая төгрөг буюу 55.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 508.4 сая төгрөг буюу 13.8 хувийг орон нутгийн төсвөөс, 1,070.2 сая төгрөг буюу 29.1 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 46.5 сая төгрөг буюу 1.3 хувийг НДС-аас санхүүжүүлэхээр хуваарилжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,082.3 сая төгрөг буюу 83.8 хувьтай байгаа нь урсгал зардлаас 254.7 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 278.4 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 54.4 сая төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 264.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 69.1 сая, НДС-ийн зардалд 2.1 сая, тогтмол зардалд 3.7 сая, хангамж бараа материалын зардалд 21.3 сая, нормативт зардалд 81.4 сая, эд хогшил урсгал засварт 5.0 сая, томилолтын зардалд 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 5.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 33.5 сая, урсгал шилжүүлэгт 34.3 сая, хөрөнгийн зардалд 8.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 59.8 сая төгрөгөөр тодотгон баталж, 57.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 65.5 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал болон өвөлжилтийн бэлтгэлд, 5.4 хувийг 2.1.4 дэх заалтын хүрээнд иргэд байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрлэхэд, 19.7 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 9.4 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 85.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 3,676.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,082.3 сая төгрөгийг зарцуулж 83.8 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 128.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 182.5 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 141.6 хувь буюу 53.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 6 нэр төрлийн орлого 3.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жаргалант сумын ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 7 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Жаргалант сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. ТШЗ-ийн аудитын дүнгийн талаар

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс тагталзсан
ИТХурал	1	1	1		1				
ЗДТГ	1	1	1		1		1		
ЕБС	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1					
ЭМТ	1	1	1		1	1			
Бага сургууль	1	1		1					
Соёлын төв	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	9	9	5	4	5	4	1		

Сумын 2021 оны санхүүгийн нэгдсэн тайланд 9 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан сумын ИТХ, ЕБС, ЭМТ, Соёлын төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, харин ЗДТГ-ын тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 344.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 152.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 292.0 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 13.6 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт 6. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: залруулагдсан алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЕБСургууль	5	9.7					2	-	3	9.7
ЗДТГ	5	294.2	1	30.3	1	0.9	3	263.0		
ИТХурал	3	14.2	1	0.4			2	13.8		
Соёлын төв	2	7.0					1	3.1	1	3.9
ЭМТөв	2	19.2	1	7.1			1	12.1		
НИЙТ ДҮН	17	344.3	3	37.8	1	0.9	9	292.0	4	13.6

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 27.4 сая төгрөгийн 7 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 279.1 сая төгрөгийн 7 зөрчил тус тус байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардлаас төсөвт зохицуулалт хийлгүйгээр 7.5 сая төгрөгөөр компьютер, техник хэрэгсэл худалдан авсан, ковид цар тахалтай холбоотойгоор иргэдээс 5.4 сая төгрөгийн хандив өгснийг зориулалт бус буюу өвөлжилтийн бэлтгэл ажил буюу өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулсан зэрэг зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.
- ЗДТГ нь түлш халаалтын зардлаас 0.9 сая төгрөгийн түлээ, нүүрсийг нөөцөлж, үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон байна.
- ЕБС нь тусгай зориулалтын материалын дансанд 9.7 сая төгрөгийн 220 ширхэг сандал ширээ, компьютер зэрэг үндсэн хөрөнгө бүртгэсэн, , ном хэвлэлийн зардлаас 0.03 сая төгрөгийг маягтны үнэ, интернэтийн төлбөр төлсөн, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй зэрэг зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.
- Соёлын төв нь тайлан балансад 10 нэр төрлийн 3.9 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө бүртгэлтэй байгаад зөвлөмж хүргүүлсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Жаргалант сумын ТЕЗ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 150 мэдээллээс 60 мэдээллийг хугацаанд нь, 42 мэдээллийг хугацаа хоцроон, 48 мэдээллийг огт мэдээлээгүй буюу ОНХС, орон нутгийн орлого, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэргийн 1-12 сар, 1-4 дүгээр улирлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансны цахим системд оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.4, 6.2.5, 6.3.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших **албан шаардлагыг** хүргүүлээ.

Жаргалант сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд ЗДТГ нь 65 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, засаг дарга даргын төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой нийт 143.4 сая төгрөгийн 16 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 106.6 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй,
- ИТХ нь 59 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 12.0 сая төгрөгийн 7 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй,
- Соёлын төв нь 8 мэдээллийг хугацаа хоцроон, 4 дүгээр улирлын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээлээгүй, Мөн төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 3.1 сая төгрөгийн 4 тушаал шийдвэрийг системд байршуулаагүй,
- ЭМТ нь 8 мэдээллийг хугацаа хоцроон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12.1 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээг системд байршуулаагүй
- ЕБС нь 6 мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээлэл огт мэдээлээгүй байна.

Шилэн данстай холбоотой дээрх зөрчлүүдэд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Жаргалант сумын ТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн хэмнэлтийг 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал

гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд ИТХ 8.3 хувь буюу 1.7 сая төгрөг, ЕБС нь 10 %-д төсвийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Иймд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах **албан шаардлага** хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, мөн бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 97.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт сая төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж-СХС	1	97.3	1	76.4		20.9	78.5
Нийт	1	97.3	1	76.4		20.9	78.5

Өмнөх зөвлөмжийн дагуу СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар албан бичгээр хариуг ирүүлсэн бөгөөд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өмнөх оноос буурсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, СХС-ийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн буцаан төвлөрүүлэлт болон Хоршоо хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 183.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 152.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 30.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлэн, дотоод хяналттай холбоотой асуудалд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

СХС нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа 152.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкны үлдэгдлээр тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

- Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад бууны албан татвар 0.4 сая, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.2 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.1 сая, хог хаягдлын хураамж 0.1 сая, нэр заагдаагүй бусад орлого 0.6 сая, ойн нөөц ашигласны төлбөр 1.0 сая төгрөг нийт 3.5 сая төгрөгөөр орон нутгийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн

төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хийж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэх албан шаардлагыг хүргүүллээ.

- Сум хөгжүүлэх сангаас зээлийн авлагыг тулган шалгахад 4 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн 12.2 сая, 4 зээлдэгчтэй холбоотой чанаргүй 8.7 сая төгрөг нийт 8 зээлдэгчтэй холбоотой 20.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын /тухайн үед хүчин төгөлдөр байсан/ 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу төвлөрүүлэхэд онцгой анхаарч, зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Тайлант хугацаанд ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн төсөвт орсон 6.6 сая төгрөгийн өөрчлөлтийг тодотгон батлуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34.2.1-т “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсөвт өөрчлөлт орсон тохиолдолд жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэн төсвийн зохицуулалтыг тодотгон тогтоолоор батлуулж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жаргалант сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналт, аудитыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн бөгөөд “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Жаргалант сумын ТЭЗ	4	183.3	1	152.4	0	0	3	30.9	1	0
	Дүн	4	183.3	1	152.4	0	0	3	30.9	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Жаргалант сумын ТЭЗ	1	0	0	0	0	0	1	0	0	0
	Дүн	1	0	0	0	0	0	1	0	0	0
	Нийт дүн	5	183.3	1	152.4	0	0	3	30.9	1	0